



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Цэцэрлэг хот
2022 он

Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх
аудитор: Т.Байгалмаа
Утас: 70333141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Нэргүйбаатар
Утас: 70332680 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn

Аудитор: П.Энхжаргал
Утас: 99743112
Цахим хаяг: enkhjargalp@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар

1.Аудитын санал дүгнэлт



ӨНДӨР-УЛААН СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА С.ВАНДАНДУЛАМ ТАНАА

2022.02.25 № 106
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29,789,677.00	50,613,407.00
33	АВЛАГА	400,000.00	0.00
33500	Бусад авлага	400,000.00	0.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	400,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	29,389,677.00	50,613,407.00
35400	Хангамжийн материал	12,221,947.00	33,445,677.00
35410	Бичиг хэргийн материал	799,647.00	866,447.00
35420	Аж ахуйн материал	11,422,300.00	32,579,230.00
35600	Мал амьтад	17,167,730.00	17,167,730.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,851,567,319.86	2,014,701,132.67
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,851,567,319.86	2,014,701,132.67
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	1,828,563,819.70	1,992,347,632.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	537,088,553.13	553,078,553.13
39202	Хуримтлагдсан элэгдэл	-113,789,122.76	-133,703,784.68
39203	Авто-тээврийн хэрэгсэл	266,206,610.00	266,206,610.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-164,628,331.50	-191,836,598.50
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	98,338,091.49	171,096,541.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59,334,617.02	-76,666,675.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,258,407.77	43,905,407.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,490,686.69	-27,305,197.86
39209	Зам, гүүрийн байгууламж	1,648,115,801.50	1,959,249,321.50
39210	Хуримтлагдсан элэгдэл	-398,273,886.22	-571,749,544.97
39217	Ном	73,000.00	73,000.00
39300	Биет бус хөрөнгө	23,003,500.16	22,353,500.24
39301	Програм хангамж	3,250,000.00	3,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,137,499.84	-1,787,499.76
39303	Бусад биет бус хөрөнгө	20,891,000.00	20,891,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,881,356,996.86	2,065,314,539.67
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,881,356,996.86	2,065,314,539.67
51	Засгийн газрын хувь оролцоо	1,881,356,996.86	2,065,314,539.67
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	496,878,327.97	496,878,327.97
51200	Хуримтлагдсан үр дүн	1,085,779,041.62	1,269,736,584.43
51210	Өмнөх үеийн үр дүн	1,102,797,687.90	1,085,779,041.62
51220	Тайлант үеийн үр дүн	-17,018,646.28	183,957,542.81
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	298,699,627.27	298,699,627.27
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,881,356,996.86	2,065,314,539.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	640,284,567.00	878,800,516.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	204,892,148.00	387,648,970.00
120	Нийтлэг татварын бус орлого	204,892,148.00	387,648,970.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	204,892,148.00	950,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,564,701.00	950,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	203,327,447.00	0.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	0.00	386,698,970.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	435,392,419.00	491,151,546.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,633,419.00	29,583,246.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,633,419.00	29,583,246.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	414,759,000.00	461,568,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	414,759,000.00	461,568,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	653,971,813.28	694,842,973.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	653,971,813.28	694,842,973.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	645,515,812.28	684,687,273.19
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,535,500.00	288,300,400.00
210101	Үндсэн цалин	248,923,200.00	262,199,674.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,612,300.00	26,100,726.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,763,400.00	38,866,800.00
210201	Тэтгэврийн даатгал	26,065,700.00	27,350,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,649,600.00	2,879,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,119,500.00	2,303,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,900.00	575,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,398,700.00	5,758,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,800,000.00	17,061,070.00
210301	Гэрэл, цахилгаан	5,734,200.00	8,166,070.00
210302	Түлш, халаалт	13,909,800.00	8,765,000.00
210303	Цэвэр, бохир ус	156,000.00	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	51,690,658.00	46,174,834.00
210401	Бичиг хэрэг	8,242,460.00	4,999,358.00
210402	Тээвэр, шатахуун	22,109,258.00	27,085,690.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,545,000.00	4,800,000.00
210404	Ном, хэвлэл	1,714,400.00	980,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,037,740.00	1,113,146.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,041,800.00	7,196,240.00
2105	Нормативт зардал	4,665,000.00	0.00
210502	Хоол, хүнс	2,480,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,185,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,098,000.00	17,098,469.19
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	7,649,969.19
210602	Тавилга	0.00	500,500.00
210604	Урсгал засвар	1,598,000.00	8,948,000.00

2107	Томилолт, зочны зардал	4,216,000.00	3,840,000.00
210702	Дотоод албан томилолт	4,216,000.00	3,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,321,221.00	19,995,078.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,816,221.00	18,354,036.67
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	605,000.00	1,039,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	412,762.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	144,430.00
210807	Газрын төлбөр	50,000.00	44,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,426,033.28	253,350,621.33
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,751,800.00	16,197,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,442,500.00	800,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	215,231,733.28	236,353,021.33
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,456,001.00	10,155,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,841,300.00	4,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,341,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	4,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	614,701.00	6,155,700.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	614,701.00	6,155,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-13,687,246.28	183,957,542.81
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,331,400.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,331,400.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-17,018,646.28	183,957,542.81

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,102,797,687.90	1,898,375,643.14
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,102,797,687.90	1,898,375,643.14
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-17,018,646.28	-17,018,646.28
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,085,779,041.62	1,881,356,996.86
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,085,779,041.62	1,881,356,996.86
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,085,779,041.62	1,881,356,996.86
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	183,957,542.81	183,957,542.81
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	496,878,327.97	298,699,627.27	1,269,736,584.43	2,065,314,539.67

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	436,957,120.00	492,101,546.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,564,701.00	950,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,564,701.00	950,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,564,701.00	950,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,564,701.00	950,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	435,392,419.00	491,151,546.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,633,419.00	29,583,246.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,633,419.00	29,583,246.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	414,759,000.00	461,568,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	414,759,000.00	461,568,300.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	434,457,120.00	472,271,546.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	434,457,120.00	472,271,546.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	426,001,119.00	462,115,846.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	271,915,500.00	287,900,400.00
210101	Үндсэн цалин	249,303,200.00	261,799,674.00
210105	Гэрээт ажлын хөлс	22,612,300.00	26,100,726.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,763,400.00	38,866,800.00
210201	Тэтгэврийн даатгал	26,065,700.00	27,350,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,649,600.00	2,879,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,119,500.00	2,303,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	529,900.00	575,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,398,700.00	5,758,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,000,000.00	22,500,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,734,200.00	8,166,070.00
210302	Түлш, халаалт	12,109,800.00	14,203,930.00
210303	Цэвэр, бохир ус	156,000.00	130,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,930,258.00	32,698,800.00
210401	Бичиг хэрэг	6,300,000.00	5,253,300.00
210402	Тээвэр, шатахуун	17,771,058.00	13,545,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,500,000.00	4,800,000.00
210404	Ном, хэвлэл	1,500,000.00	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,559,200.00	5,500,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	3,100,000.00
2105	Нормативт зардал	2,400,000.00	520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,400,000.00	520,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,898,000.00	9,294,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	0.00
210604	Урсгал засвар	1,398,000.00	9,294,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,216,000.00	3,840,000.00
210702	Дотоод албан томилолт	4,216,000.00	3,840,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,222,361.00	30,595,846.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,717,361.00	28,661,546.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	605,000.00	1,039,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	500,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	350,000.00	250,000.00
210807	Газрын төлбөр	50,000.00	45,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,655,600.00	35,900,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,855,600.00	35,100,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,800,000.00	800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,456,001.00	10,155,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,841,300.00	4,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	4,341,300.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	4,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	614,701.00	6,155,700.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	614,701.00	6,155,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,500,000.00	19,830,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,500,000.00	19,830,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,500,000.00	19,830,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,500,000.00	19,830,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,500,000.00	19,830,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,500,000.00	-19,830,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	540,783,200.00	456,362,600.00	84,420,600.00	84.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	486,362,600.00	456,362,600.00	30,000,000.00	93.83
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	483,362,600.00	453,362,600.00	30,000,000.00	93.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	287,900,400.00	287,900,400.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	265,287,600.00	261,799,674.00	3,487,926.00	98.69
210105	Гэрээт ажлын хөлс	22,612,800.00	26,100,726.00	-3,487,926.00	115.42
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,866,800.00	38,866,800.00	0.00	100.00
210201	Тэтгэврийн даатгал	27,350,700.00	27,350,700.00	0.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,879,000.00	2,879,000.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,303,300.00	2,303,300.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	575,800.00	575,800.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,758,000.00	5,758,000.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,500,000.00	22,500,000.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	7,700,000.00	8,166,070.00	-466,070.00	106.05
210302	Түлш, халаалт	14,670,000.00	14,203,930.00	466,070.00	96.82
210303	Цэвэр, бохир ус	130,000.00	130,000.00	0.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,153,300.00	32,153,300.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	5,253,300.00	5,253,300.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,000,000.00	13,000,000.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800,000.00	4,800,000.00	0.00	100.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,500,000.00	5,500,000.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,100,000.00	3,100,000.00	0.00	100.00
2105	Нормативт зардал	520,000.00	520,000.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	520,000.00	520,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,624,000.00	23,624,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,330,000.00	14,330,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	9,294,000.00	9,294,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,840,000.00	3,840,000.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	3,840,000.00	3,840,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,658,100.00	22,658,100.00	30,000,000.00	43.03
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,723,800.00	20,723,800.00	30,000,000.00	40.86
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,039,000.00	1,039,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	500,000.00	500,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00	0.00	100.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	250,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	45,300.00	45,300.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,300,000.00	21,300,000.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,500,000.00	20,500,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	800,000.00	800,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	3,000,000.00	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,420,600.00		54,420,600.00	0.00
222001	Тоног төхөөрөмж	54,420,600.00		54,420,600.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	540,783,200.00	456,362,600.00	84,420,600.00	84.39
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	539,833,200.00	455,412,600.00	84,420,600.00	84.36
320001	Орон нутгийн төсвөөс	539,833,200.00	455,412,600.00	84,420,600.00	84.36
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	950,000.00	950,000.00	0.00	100.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	950,000.00	950,000.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	29	29	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	3	3	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	17	17	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	4	4	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31 өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,583,246.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,583,246.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,583,246.00
2104	Хангамж, бараа материалын зардал	545,500.00
210402	Тээвэр, шатахуун	545,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,437,746.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,437,746.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	29,583,246.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,583,246.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,583,246.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор П.Энхжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Өндөр-Улаан сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/29 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өндөр-Улаан сумын ЗДТГ нь Нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэр, Улсын Их Хурлаас гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, түүнтэй нийцүүлэн гаргасан нутгийн захиргааны шийдвэрүүдэд хяналт тавьж биелэлтийг хангуулахын тулд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын хяналтын багийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өндөр-Улаан сумын ЗДТГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн. Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 540.8 сая төгрөгөөс 1%-иар буюу 5.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 %-иар буюу буюу 4.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 183.9 сая төгрөгөөр буюу 9.8 хувиар өссөн байна. Оны эхний үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
1	2	3	4=3-2	
Авлага	0.4		-0.4	-100.0
Бараа материал	29.4	50.6	21.2	72.1
Үндсэн хөрөнгө	1851.6	2014.7	163.1	8.8
Нийт хөрөнгө	1881.4	2065.3	183.9	9.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1881.4	2065.3	183.9	9.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1881.4	2065.3	183.9	9.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Авлагын эхний үлдэгдэл 0.4 сая төгрөг бүрэн барагдсан байна.

- *Бараа материал эхний үлдэгдлээс 21.2 сая төгрөг буюу 72.1 хувиар өссөн байна.*

Бараа материалын данс нь 29.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 93.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 72.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулан оны эцэст 50.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Үндсэн хөрөнгө эхний үлдэгдлээс 163.1 сая төгрөг буюу 8.8 хувиар өссөн байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 1,851.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд 19.8 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 386.7 сая төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн, нийт 406.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 243.5 сая төгрөгийн элэгдэлийн зардлаар буурч 2,014.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- *Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнтэй холбоотой бөгөөд тайлант хугацаанд 183.9 сая төгрөгийн үр дүнг хүлээн зөвшөөрсөн байна.*

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Зөрүү
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	713.7	638.2	-75.5
2	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.5	1.6	1.1
3	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	283.2	155.8	-127.4
4	Нэмэлт санхүүжилтийн орлого	49.2	28.9	-20.3
5	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	380.8	451.9	71.1
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	574.7	609.9	35.2
7	Бараа, ажил үйлчилгээний зардал	478.4	503.3	24.9
8	Урсгал шилжүүлэг	55.9	105.7	49.8
9	Үндсэн хөрөнгө худалдсны гарз	40.4	0.9	-39.5
10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	98.6	27.4	-71.2

Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 75.5 сая төгрөг буюу 10.6 хувиар буурсан нь үнэ төлбөргүй орлого, нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 427.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 113.4 сая төгрөгөөр өсгөж нийт зардлыг 540.8 сая төгрөгөөр хянаж баталжээ. Энэ нь ИТХ-ын тэргүүлэгчдээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэн баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 540.8 сая төгрөгийн төсөв батлагджээ. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 540.8 сая төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 1.0 сая төгрөгийн санхүүжилт авч 456.4 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаандаа зарцуулж 84.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь хөрөнгийн зардлаас 84.4 сая төгрөг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 29.6 сая төгрөгийн орлого төвлөрч дараах арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 10.0 сая төгрөгийн санхүүжилт ирснийг сумын Засаг даргын захирамжаар ковид 19 цар тахлын тусгаарлах байрны хоол, хүнс, шатахуун, бусад зардалд зарцуулсан байна.

- Аймгийн Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогод зориулж 1.4 сая төгрөг, Ар ус Ундарга ХХК-аас усны төлбөрт 6.2 сая төгрөг, аймгийн Мал эмнэлгийн газраас тасгийн засварт зориулан 5.0 сая төгрөг, аймгийн ГХБЗХГ-аас хүүхэд хамгааллын зардалд 1.1 сая төгрөг, аймгийн ЗДТГ-аас цэрэг хүргэлтийн шатахуунд 1.3 сая төгрөг, нийт 25.0 сая төгрөгийн санхүүжилтийг сумын Засаг даргын захирамж шийдвэрийн дагуу зарцуулсан байна.

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 15 дугаар зүйлийн 15.1 дэх заалтын дагуу иргэн, аж ахуйн нэгжүүдээс ковид 19 цар тахалтай холбоотой 4.6 сая төгрөгийн хандивын орлого төвлөрснийг сумын Засаг даргын 2021 оны захирамжийн дагуу тусгаарлах байрны ариутгалын бодис, хамгаалах хэрэгсэлд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд иргэдэд ковидоос урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж хүргүүлэх, хөдөлгөөнт эргүүл хийх, өөр бусад ажлаар хувийн автомашинд 9.8 сая төгрөгийн шатахуун зарцуулж ажилласан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 95.0 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 540.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 84.4 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд орон тоо нэмэгдүүлээгүй, шагнал, урамшуулалд 20.9 сая төгрөг зарцуулсан, автомашин худалдан аваагүй байна.
2. Суудлын автомашин ашиглалтын хувьд: Тус байгууллага нь 2008-2017 онуудад үйлдвэрлэгдсэн 39.3 сая төгрөгийн төсөв бүхий 2 автомашин ашигладаг бөгөөд жилийн шатахууны зардалд 2.4 сая төгрөг, сэлбэг хэрэгслийн зардалд 1.5 сая төгрөгийг тус тус зарцуулж, үндсэн орон тооны 1 жолоочтой байна.
3. Ковид-19 цар тахалтай холбоотой иргэдээс 4.6 сая төгрөгийн мөнгөн хандив хүлээн авч зарцуулсан байна.
4. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд Өндөр-Улаан сумын ЗДТГ нь 5.5 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэсэн ЗГ-ын 43-р тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Өндөр-Улаан сумын ЗДТГ нь 2021 онд нийт 89.5 сая төгрөгийн 146 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь ил тод мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 39.4 хувь буюу 84.4 сая төгрөгийн хэмнэлт бий болгосон байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт нийцэж нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өндөр-Улаан сумын ЗДТГ-ын эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийхэд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна. Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналттай холбоотой зөвлөмж хүргүүлснийг хэрэгжүүлж биелэлтийг 2021 оны 5 дугаар сарын 31-ний 02/15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.12 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд Өндөр-Улаан сумын ЗДТГ нь 5.5 сая төгрөгөөр тавилга, эд хогшил бэлтгэсэн ЗГ-ын 43-р тогтоолын 1.4 дэхь заалтыг зөрчсөн алдаа зөрчлийг материаллаг бус гэж үзсэн тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Өндөр-Улаан сумын ЗДТГ										
Санхүүгийн тайлангийн аудитын шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Өндөр-Улаан сумын ЗДТГ	1	5.5					1	5.5		
НИЙТ ДҮН		1	5.5					1	5.5		